

16

МОНГОЛ ДАХЬ САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

М.Эрдэнэбат, Б.Хүрэлбаатар, Н.Саруултөгс

*“Өмчийг өмчлөх бус, харин ашиглах эрх эдлэх нь жинхэнэ баялаг”
Аристотель*

Санхүүгийн түрээс гэж юу вэ? Санхүүгийн түрээс нь түрээслүүлэгчийн өмчлөлийн тодорхой хөрөнгийг тогтоосон хугацаанд тохиролцсон хариу төлбөр /ерөнхийдөө үечилсэн мөнгөн төлбөртэйгээр болох түрээсийн төлбөр/-тэй ашиглах эрхийг түрээслэгчид олгодог түрээслүүлэгчийн ба түрээслэгчийн хоорондох гэрээ хэлцэл бөгөөд эдийн засаг тогтворжиж, үндэсний үйлдвэрлэл хөгжиж буй өнөө үед шинэ ба хөгжиж буй компаниудын хөрөнгө оруулалтын боломжыг нэмэгдүүлж, зах зээл дэх өсөлтийг хангахад нэн шаардлагатай байгаа санхүүгийн хэрэгсэл юм. Энэ нь үйл ажиллагааны түрээсээс ялгаран дараах үндсэн шалгууртай байдаг.

Санхүүгийн түрээсийн үндсэн шалгуур

1. Өмчлөх эрхийн шилжилт -. Хэрэв түрээс нь хөрөнгийн өмчлөлийг түрээслэгчид шилжүүлж байвал энэ нь санхүүгийн түрээс болно.
2. Тохиролцон худалдан авах сонголт – түрээсийн хугацааны төгсгөлд уг хөрөнгийг хүлээгдэж буй зах зээлийн үнээс маш хямд бага үнээр түрээсэлсэн хөрөнгийг худалдан авах боломжийг түрээслэгчид олгож байх
3. Үр ашигт хугацаа - Хэрэв түрээсийн хугацаа нь хөрөнгийн үр ашигтай хугацааны дийлэнхи /ихэвчлэн 75% буюу түүнээс дээш/ бол өмчлөлийн ихэнх эрсдэл ба шагнал түрээслэгчид шилждэг гэж үздэг.
4. Хөрөнгө оруулалтын нөхөлт - хамгийн бага түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь уг хөрөнгийн зах зээлийн үнэтэй /90% буюу түүнээс дээш/ нэлээд ойролцоо бол тухайн хөрөнгийг ихээхэн худалдан авах юм.
5. ННБОУСтандартаар - түрээслэж буй хөрөнгө нь биет чанартай бөгөөд түрээсийн хугацаанд ямар нэг томоохон өөрчлөлт оруулдаггүй байх.

Хэдийгээр түрээс нь зээлийн нэгэн төрлийн хэлбэр боловч зээлийн худалдан авалт, банкны зээлээс дараах давуу талуудыг түрээслэгчид олгодог.

1. Тогтмол төлбөртэй 100 хувийн санхүүжилт - түрээс нь түрээслэгчээс аливаа бэлэн мөнгөн төлбөр хийхийг шаарддаггүй учраас ховор хомс мөнгөн хөрөнгийг нөөцлөхөд туслахаас гандна ихэвчлэн түрээсийн төлбөрүүд тогтмол байдаг учраас түрээслэгчийг имфляци, мөнгөний өртөг зардалын өсөлтөөс хамгаалдаг.

2. Хуучралтаас хамгаалах - тоног төхөөрөмжийн түрээслэлт нь түрээслэгчид учрах хуучралтын эрсдлийг багасгадаг бөгөөд ихэнх тохиолдолд үлдэх үнэ цэнийн эрсдлийг түрээслүүлэгчид шилжүүлдэг.

3. Уян хатан байдал - түрээсийн гэрээ нь өр төлбөрийн бусад хэлцлээс арай хязгаарлалт бага бөгөөд түрээслүүлэгчид нь түрээслэгчийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн түрээсийн гэрээ хийдэг.

4. Зардал багатай санхүүжилт - зарим компани санхүүжилтийн аливаа бусад хэлбэрээс түрээс арай хямд, барьцаа шаарддаггүй гэж үздэг. Тухайлбал өрсөлдөөн ихтэй салбарт үйл ажиллагаа эхлэж байгаа компаниуд эсвэл татварын хамгаалалт багатай компаниуд нь алдаж байсан татварын хэмнэлтээ нэхэмжлэх хэрэгсэл болгон түрээслэж болно.

5. Балансын гадуурах санхүүжилт - Зарим түрээс нь балансын өр төлбөрийг нэмэгдүүлэхгүй эсвэл санхүүгийн харьцаанд нөлөөлөхгүй боловч зээл авах чадварыг нэмэгдүүлж болно.

Иймээс манай зах зээлд хөгжиж эхэлж буй энэ үйлчилгээний бүртгэл, тооцоолол, тайлагнах арга зүйг судалж улсынхаа онцлогыг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймд энэ судалгааны зорилго нь лизингийн үйлчилгээ ямар түвшинд явагдаж байгааг тодорхойлох, цаашид зах зээл өндөр хөгжсөн орнуудын жишигт хүргэж хөгжүүлэхэд ямар хүчин зүйлс саад болж байгааг тогтоох зорилгоор хийлээ.

Манай улсад өнөөгийн байдлаар лизинги ямар түвшинд байна вэ?

Орчин үеийн санхүүгийн түрээс буву лизинг нь 1950-иад оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд манай улсын хувьд 2004-2008 оны засгийн газрын санхүүгийн салбарын хүчтэй болгох, ялангуяа санхүүгийн түрээсийг хөгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар эрх зүйн орчиныг бүрдүүлж лизингийн үйлчилгээг бүрдүүлж эхэлсэн. Манай улсад лизингээр 3 төрлийн хөрөнгийг санхүүжүүлж байна.

1. Хэрэглээний бараа
2. Хүнд тоног төхөөрөмж
3. Тээврийн хэргсэл

Хууль эрх зүйн орчин. Монгол улсын засгийн газрын 64 дүгээр тогтоолоор батлагдсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт техник технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох эрх зүйн орчиныг бүрдүүлэхээр тусгаж үүний үрээр өнгөрсөн 2006 онд санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн анх баталсан бөгөөд үүнтэй уялдуулан татварын шинэчилсэн зарим хуулиудад холбогдох өөрчлөлүүтийг оруулсан нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн асуудал шийдэгдэх үндэс тавигдсан гэж үзэж болох юм.

Түрээслэгч буюу эрэлт. Өнөөгийн байдлаар манай улсын нийт ажлын байрны 70 орчим хувийг хангаж 300 мянга гаран хүн ажилладаг 25

мянга орчим жижиг, дунд үйлдвэр аж ахуйн газрууд улсын төсвийн 1,8 хувийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна гэсэн үйлдвэрлэл худалдааны яамны судалгаанаас үзвэл эдгээр аж ахуйн нэгжийн хөгжилд үйлдвэрлэгчдийг урт хугацааны туршид өрсөлдөх чадвартай болгох, үр ашигтай ажиллах нөхцлийг хангах зорилгоор санхүүгийн түрээсийн механизмыг нэвтрүүлэх шаардлагатай байна. /2005 оны байдлаар хүснэгт 1/

хугацаа	тоног төхөөрөмж		тоног төхөөрөмж	
	түрээслэгчийн тоо	хувь	нийт лизинг ам.доллар	хувь
1 жилээс доош	79	81.44%	526,874	18.99%
1 жилээс дээш	18	18.56%	2,247,373	81.01%
нийт	97	100.00%	2,774,247	100.00%

Эндээс харвал аж ахуйн нэгжүүд хэрэгцээтэй тоног төхөөрөмжөө лизингээр авсан түрээслэгчийн тоо нь 1 жилээс дотогш хугацаанд 81,44% буюу өндөр байгаа мэт боловч нийт түрээсийн санхүүжигдсэн дүнгийн хувьд 19% байгаа нь санхүүгийн түрээсийг хэрэгжүүлж байгаа банк болон санхүүгийн байгууллагын явуулж байгаа бодлогод сонголт байхгүйтай холбоотой. Мөн 1 жилээс дээш хугацаанд буюу урт хугацаанд тоног төхөөрөмжийг түрээслэх нь тоон үзүүлэлтийн хувьд 18,6%, нийт түрээсийн санхүүжигдсэн дүнгийн хувьд 81% байгаа нь түрээслэгчид санхүүгийн түрээсийг урт хугацаанд авч ашиглах эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байгаа юм.

Түрээслүүлэгч-нийлүүлэлт. Манай улсын хэмжээнд Лизингийн үйлчилгээ үзүүлж байгаа 13 байгууллага байгаагаас 7 арилжааны банк, 2 банк бус санхүүгийн байгууллага, үлдсэн нь тоног төхөөрөмж нийлүүлэгч компаниуд байгаа бөгөөд Эдгээрээс арилжааны банкууд нь олон төрлийн лизингийн үйлчилгээ санал болгож байгаагийн ихэнхи нь хэрэглээний бараа, / гэр ахуйн цахилгаан бараа, тээврийн хэрэгсэл, гар утас/ болон орон сууцны, тоног төхөөрөмжийн зээлийн хэлбэрээр санхүүжилт олгож байна. Банкууд нь лизингийн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагатай харицуулбал эх үүсвэрийн хувьд /хадгаламж татдаг/ бага зардлаар санхүүждэг давуу талтай хэдий ч эрсдэлийг бууруулах, зохистой харицааг баримтлах зэрэг хатуу хяналттай тул барьцаа хөрөнгө шаарддаггүй, урт хугацаатай, уян хатан нөхцөлтэй лизингийг бүрэн хэрэгжүүлээд байж чаддаггүй зөвхөн богино хугацаанд /ихэвчлэн 12 сар хүртэл/ хэрэглээний барааг санхүүжүүлж байна.

/2005 оны байдлаар хүснэгт 2/

хугацаа	хэрэглээний бараа	хэрэглээний бараа
---------	-------------------	-------------------

	Түрээслэгчийн тоо	хувь	нийт лизинг /ам.доллар/	хувь
1 жилээс доош	23287	98.77%	6,951,984	86.74%
1 жилээс дээш	289	1.23%	1,062,879	13.26%
нийт	23576	100.00%	8,014,863	100.00%

Эндээс дүгнэж үзвэл нийт банкуудын хэрэглээний бараанд санхүүгийн түрээсээр олгосон нийт санхүүжилтийн 86,7%ийг 1 жилээс дотогш хугацаагаар буюу нийт хэрэглээний зээлийн 98,8% нь болж байна. Гэтэл 1 жилээс дээш хугацаатайгаар түрээслэсэн түрээслэгчийн тоо 1,2% буюу 13,26% байгаа нь өндөр үнэтэй хэрэглээний барааг санхүүжүүлсныг харуулж байна.

Лизингийн хөгжилд юу саад болж байна вэ?

- Хэдийгээр үндсэн хөрөнгийг лизингээр худалдаалах хэлбэр байгаа ч энэ нь ихэвчлэн хэрэглээний зээл буюу зээлээр худалдан авах хэлцэл болчихсон байна. Өөрөөр хэлбэл түрээслүүлэгч байгууллагууд нь санхүүгийн хувьд бүрэн бие даагаагүй учраас удаан хугацаагаар түрээс олгох боломж бага бөгөөд ихэвчлэн 36 сарын хугацаагаар лизингийн үйлчилгээ үзүүлж байна. Иймээс лизинг нь хөрөнгийн ашиглах хугацаатай харицуулбал богино хугацаанд хийгдэж, борлуулалтыг л дэмжсэн үйл ажиллагаа болон хувирчээ. Жишээлбэл үр ашигт хугацааны буюу санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5,1,2 заасан шаардлагыг хангасан түрээс огт хийгдэхгүй байна.

- Банкуудын лизингээр дэмжуулан зээлийн бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай борлуулж, чөлөөт эх үүсвэрээ бүхлээр нь ашиглаж байгаа тул тэдгээр нь лизингийг сонгодог утгаар нь хөгжүүлэх сонирхолгүй байдаг.

- Мөн банкууд нь засгийн газрын шугамаар хөнгөлөлттэй нөхцлөөр олгож буй төслийн зээлүүдийг хэрэгжүүлж буй учраас энэ нь эргээд лизингийн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй байгууллагуудад маш хүчтэй өрсөлдөөн бий болгож байна.

- Банкууд лизингээр хөрөнгө санхүүжүүлсэн зарим тохиолдолд тухайн нийлүүлэгч компаниас үнийн урамшуулал авдаг ч түрээслэгчид үүнийг мэддэггүй.

- Донор орны, байгууллагын санхүүжилттэй төсөл нь ихэвчлэн үйл ажиллагааны лизингийг илүүтэй сонирхдог.

- Түрээслүүлэгч компаниудын лизингийг санхүүжүүлэх эх үүсвэр хангалтгүй байгаа.

- Татварын хуулиар санхүүгийн түрээсийг санхүүгийн үйлчилгээ гэж үздэггүй зэрэг олон бодит саад байна.

Шийдэх боломж Хуулийн илүү таатай орчныг бүрдүүлэх. Санхүүгийн түрээсийг татварын багц хуулиудад санхүүгийн ажил гүйлгээний нэгэн адил авч үзэж зээлийн үйл ажиллагаатай адил нөхцлөөр хангах. Өөрөөр хэлбэл НӨАТ-ын тухай хуульд лизингийн үйлчилгээг борлуулалтын үйл ажиллагаа бус харин санхүүгийн үйл ажиллагаа гэдэг утгаар нь авч үзэх.

